



## БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ БОДЛОГО

### Нэг. Зорилго

- 1.1 “Эм Ди Эс Системс” ХХК (цаашид “Агирэ” гэх) нь Нэгдсэн Үндэсний Байгууллагаас баталсан “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд” болон “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ыг тус тус үндэслэн эмэгтэйчүүдийн алдагдсан боломжийг тэгшитгэхэд хувь нэмрээ оруулах, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжиж компанийн үйл ажиллагааны хүрээнд эмэгтэй бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү бодлогын баримт бичгийг баталж байна.
- 1.2 Энэхүү бодлогын баримт бичиг нь Айгэрэ системд бүртгэлтэй, энэхүү бодлогын баримт бичигт заасан шаардлагыг хангасан хэрэглэгчид хамаарна.

### Хоёр. Тавигдах шаардлага

- 2.1 Бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 2.1.1. “Бичил бизнес эрхлэгч” буюу 10 хүртэлх ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуй эрхлэгч байна.
  - 2.1.2. “Аж ахуй эрхлэгч” буюу хувь хүн бол эмэгтэй байх, хуулийн этгээд бол хувь нийлүүлсэн хөрөнгийн тавиас дээш хувийг эзэмшигч нь, эсхүл гүйцэтгэх захирал нь эмэгтэй байх шаардлагатай. Мөн хөдөлмөр эрхлэх боломжгүй, хөдөлмөрийн завсарлага авсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн бизнесийг хамруулан ойлгоно.

### Гурав. Бичил бизнес эрхлэгчийг дэмжих үйл ажиллагаа

- 3.1 Агирэ нь энэхүү бодлогын баримт бичигт заасан шаардлагыг хангасан бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулан дараах үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - Үйлчилгээний багцаа 30 хүртэлх хувийн хямдралтай үнээр санал болгоно. (Үйлчилгээний багцын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [www.igeree.mn](http://www.igeree.mn) цахим хуудаснаас үзнэ үү.)
  - Эмэгтэй бичил бизнес эрхлэгчдэд зориулсан улиралд нэгээс доошгүй удаа хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр сургалт зохион байгуулна.
  - Эмэгтэй бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зөвлөгөө өгөх нэгдсэн өдөрлөгийг жилд нэг удаа зохион байгуулна.
  - Эмэгтэй бизнес эрхлэгчдэд тулгамддаг эрх зүйн асуудлын талаар судалгаа хийж, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн мэдээ мэдээллийг өөрийн цахим хуудсаар түгээнэ.
- 3.2 Агирэ платформын үйлчилгээний талаарх санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, бодлогын баримт бичгийн агуулгыг өргөжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### Дөрөв. Хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам



- 4.1 Энэхүү бодлогын баримт бичгийн 3.1-т заасан үйлчилгээ, үйл ажиллагаанд хамрагдахыг хүсвэл дор дурдсан баримт бичгүүдийг [info@igeree.mn](mailto:info@igeree.mn) мэйл хаяг руу илгээнэ үү. Баримт бичгүүд:
- Хүсэлт (хавсралт №1-т заасан маягт);
  - Хүсэлт гаргагч нь хувь хүн бол иргэний үнэмлэхийн хуулбар, аж ахуйн нэгж бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хоёр болон түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэй бол дүрмийн хуулбар;
  - Нийгмийн даатгалын лавлагаа;
  - Татварын сүүлийн 2 жилийн тайлан /аудитлагдсан байх шаардлагагүй/.
- 4.2 Агирэ нь хэрэглэгчийн хүсэлт, хавсралт баримт бичгийг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шалган шийдвэрлэж, хүсэлт гаргагчид хариу мэдэгдэнэ.
- 4.3 Агирэ нь хүсэлтийг шийдвэрлэх явцад шаардлагатай гэж үзвэл хүсэлт гаргагчаас нэмэлт тодруулга авах эрхтэй болно.

**Бидэнтэй холбоо барих:**

77330049 дугаар болон [info@igeree.mn](mailto:info@igeree.mn) мэйлээр холбогдоно уу.



### ХАВСРАЛТ 1. ХҮСЭЛТИЙН МАЯГТ /хувь хүн/

Бодлогод хамрагдахыг хүсч буй шалтгаан:	
Аль төрлийн үйлчилгээнд хамрагдахыг хүсч буйг сонгоно уу.	<input type="checkbox"/> 30 хүртэлх хувийн хямдралтай үйлчилгээний багц
	<input type="checkbox"/> Хөдөлмөрийн эрх зүйн чиглэлийн сургалтанд хамрагдах
	<input type="checkbox"/> Эрх зүйн зөвлөгөө өгөх өдөрлөгт оролцох
Үйл ажиллагааны чиглэл:	
Жилийн орлогын хэмжээ:	
Хүсэлт гаргагчийн овог, нэр:	
Хүсэлт гаргагчийн регистрийн дугаар:	
Холбоо барих дугаар:	
И-мэйл:	
Айгэрээд бүртгэлтэй и-мэйл:	
Хавсаргах:	<ul style="list-style-type: none"><li>• Иргэний үнэмлэхийн хуулбар</li><li>• Нийгмийн даатгалын лавлагаа</li><li>• Татварын сүүлийн 2 жилийн тайлан /аудитлагдсан байх шаардлагагүй/</li></ul>



**ХАВСРАЛТ 1. ХҮСЭЛТИЙН МАЯГТ /хуулийн этгээд/**

Бодлогод хамрагдахыг хүсч буй шалтгаан:	
Аль төрлийн үйлчилгээнд хамрагдахыг хүсч буйг сонгоно уу.	<input type="checkbox"/> 30 хүртэлх хувийн хямдралтай үйлчилгээний багц
	<input type="checkbox"/> Хөдөлмөрийн эрх зүйн чиглэлийн сургалтад хамрагдах
	<input type="checkbox"/> Эрх зүйн зөвлөгөө өгөх өдөрлөгт оролцох
Хуулийн этгээдийн нэр, хэлбэр:	
Хуулийн этгээдийн регистрийн дугаар:	
Үйл ажиллагааны чиглэл:	
Жилийн орлогын хэмжээ:	
Төлөөлөх ажилтны овог, нэр:	
Холбоо барих дугаар:	
И-мэйл:	
Айгэрээд бүртгэлтэй и-мэйл:	
Хавсаргах:	<ul style="list-style-type: none"><li>• Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар</li><li>• Нийгмийн даатгалын лавлагаа</li><li>• Татварын сүүлийн 2 жилийн тайлан /аудитлагдсан байх шаардлагагүй/</li></ul>